Орон бүхний пролетари нар нэгдэгтүн!

Анхдугаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, А.Д.Х.Гүйцэтгэх захиргааны сонин.

18 дахь жилдээ | № 14 (1415) | 1965 оны 2 дугаар сарын 25 | ПҮРЭВ

## ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТЭРГҮҮНИЙ САЙЧУУДЫН ЗӨВЛӨЛГӨӨН

1965 оны 2 дугаар сарын 11-ний өглөө насныхаа ихэнхэд таван хушуу мал хариулж үлэмжийн их туршлага хуримтлуулсан өвгөд эмгэд, тэдний ажлын сонгодог арга барилыг эзэмшсэн хөдөө нутгийн охид,хөвгүүд, үйлдвэр, худалдаа тээвэр холбоо барилга, соел үйлчилгээний газруудын тэргүүний сайчуудаар аймгийн соелын ордон пиг дүүрсэн байлаа. Аймгийн намын хорооны товчоо, АДХ—ын Гүйцэтгэх захиргааны гишүүд, төв, хөдөөгөөс шалгаран ирсэн үйлдвэрлэн бүтээгчид, малчид, тариачдын төлөөлөгчид хурлын тэргүүлэгчдийн байранд гарч ирэхэд зөвлөлгөөний-хөн халуун дотно угтав. Аймгийн АДХ—ын Гүйцэтгэх захиргааны дарга Ц.Жамсран 1964 онд тус аймгийн хөдөө аж ахуй, үйлдэр ,худалдаа, тээвэр холбоо, соел үйлчилгээний ажилчдын үйлдвэрлэлийн тэргүүний сайчуудын зөвлөлгөөчийг нээж, аймгийн намын хороо, АДХ—ын Гүйцэтгэх захиргааны өмнөөс зөвлөлгөөнийхөнд баяр хүргэв. Тус зөвлөлгөөнд «хөдөө аж ахуй, үйлдвэр, худалдаа. тээвэр холбоо барилга, соел үйлчилгээний газруудад тэргүүн туршлага шинэ санаачлагыг бүтээл, чээр нэвтрүүлье» гэсэн илтгэлийг аймгийн намын хорооны нарийн бичгийн дарга Д.Дамбажамц тавив.Энэ зөвлөлгөөнөөр Лүн сумын „Энхтуул“нэгдлийн хоньчин Рэнчиндорж, Баянцагаан сумын „Өрнөх амьдрал“ нэгдлийн хоньчин эмэгтэй Гармаа, Баянзүрх сумын зоо-техникч Дэмчиг нар БНМАУ—ын аварга төлчин цолоор, Баян сумын тэмээчин Галсандулам, Гачууртын сангийн аж ахуйн саальчин Цэндээхүү,Эрдэнэ сумын анчин Дамба нарын зэрэг 34 хүн аймгийн 1964 оны аварга цолоор тус тус шагнагдав. Үйлдвэрлэлийн тэргүүний сайчуудын зөвлөлгөөнөөс аймгийн бүх хөдөлмөрчдөд хандаж уриалга гаргав.

# Тэргүүн туршлага, шинэ санаачлагыг бүтээлчээр нэвтрүүлье

### Аймгийн үйлдвэрлэлийн тэргүүний сайчуудын зөвлөлгөөн дээр аймгийн намын хорооны нарийн бичгийн дарга Д.Дамбажамцын тавьсан ИЛТГЭЛЭЭС

НӨХӨД ӨӨ!

1964 онд тус аймгийн 27 сум-нэгдэл, сум сангийн аж ахуйнуудын дотроос Батсүмбэр, Өндөрширээт сумд ба Баянчандманий хороо захиргаа мал өсгөх 1964 оны төлөвлөгөөг төрөл бүр дээр нь 101,8—116,6 хувиар биелүүлснээр аймагтаа 1964 онд зарласан социалист уралдаанд шалгарч аймгийн намын хороо, АДХ—ын Гүйцэтгэх захиргааны өндөр хайр шагналыг саяхан хүлээн авлаа.

Тус аймгийн Баянцагаан, Борнуур, Баян, Гачуурт, Жаргалант, Өнжүүл, Зуунмод хороо захиргаа зэрэг 7 сум-нэгдэл, сум сангийн аж ахуй ба хороо захиргаад 1964 оны мал өсгөх төлөвлөгөөг төрөл бүрээр нь биш боловч ерөнхий дүнгээр нь 100—109,7 хувиар биелүүлж сайхан амжилт гаргав.

Алтанбулаг, Бүрэн, Мөнгөнморьт, Сэргэлэн, Эрдэнэ сумд мал өсгөх төлөвлөгөөг биелүүлээгүй боловч өнгөрсөн онд байсан малаа 1648 хүртэл толгойгоор өсгөлөө. Өөрөөр хэлвэл тус аймгийн 27 сум нэгдэл, сум сангийн аж ахуйн дотроос дээр дурьдсан 15 сум нь малаа өсгөсний үрээр тус аймгийн нийт мал сүрэг өнгөрсөн оныхоосоо 1964 онд 0,2 хувиар буюу 3500 толгойгоор өсчээ.

Гэтэл Архуст, Баяндэлгэр, Баянзүрх, Дэлгэрхаан, Заамар, Баянцогт, Лүн, Тариат, Угтаалцайдам, Эрдэнэсант сумд 1964 оныхоо мал өсгөх төлөвлөгөөг биелүүлэх нь байтугай өнгөрсөн онд байсан малаа 128—7541 толгойгоор хорогдуулснаас аймаг 1964 оныхоо мал өсгөх улсын төлөвлөгөөг тасалдуууллаа.

Мал аж ахуйн ерөнхий өсөлтийн дотор нэгдэл,сангийн аж ахуйн, нийгмийн малын өсөлтийг авч үзвэл Батсүмбэр, Борнуур, Гачууртын сангийн аж ахуйнууд мал өсгөх төлөвлөгөөг төрлөөр нь ба ерөнхий дүнгээр нь биелүүлж, Жаргалантын сангийн аж ахуй өнгөрсөн онд байсан малаа өсгөж, Архуст, Баянцогт, Угтаалын сангийн аж ахуйнууд малаа хорогдуулсан боловч сангийн аж ахуйн нийгмийн мал 2500 гаруй толгойгоор өсчээ. Хэрэв хоцрогдсон энэ гурван сангийн аж ахуй нь түрүүлсэн 4 сангийн аж ахуйнхаа адил ажилласан бол сангийн аж ахуйнуудын малын өсөлт үүнээс улам илүү байх байсныг бид онцлон тэмдэглэж байна.

Тус аймгийн 18 нэгдлүүдийн дотроос Өндөрширээтийн „Хөгжлийн зам“, Баянцагааны „Өрнөх амьдрал“ нэгдлүүд мал өсгөх төлөвлөгөөг 101—103,8 хувиар биелүүлсэн боловч бусад 16 сум нь мал өсгөх төлөвлөгөөг тасалдуулсны дотор Баянжаргалан, Баяндэлгэр, Тариат, Лүн, Баянзүрх зэрэг 8 сумын нэгдлүүд нийгмийнхээ малыг 26000 гаруй толгойгоор хорогдууллаа.

Үүнээс болж аймгийн хэмжээгээр нэгдлийн нийгмийн мал өнгөрсөн оныхоосоо 9000 гаруй толгойгоор хорогдсон байна.

Манай зарим секторын мал ийнхүү хорогдсоны гол шалтгаан бол мал сүргийг зуд ба зуны хүйтэн бороо зэрэг байгалийн бэрхшээл, элдэв өвчнөөр үхүүлэх, арчиллагаа маллагааны муугаас хээрийн нохойд идүүлэх, хээл хаяуулах, сувайруулах гарсан төлийг мал болгож чадахгүй үхүүлэх зэргээс болж 1964 онд бараг 200 шахам мянган толгой малыг гарзадсанаас болжээ.

Хэрэв энэ хорогдсон малыг дан хонь гэж үзээд хонь нэг бүрийг 100 төгрөг гэж бодвол 20 сая төгрөг буюу аймгийн бүтэн нэг жилийн төсөвтэй тэмцэх их хохиролыг хүлээжээ. Иймд нэг ч малыг зуд ба өвчнөөр үхүүлэх, чононд идүүлэх, хээл хаяуулах, сувайруулах, гарсан төлийг үхүүлэхгүйн төлөө тэмцэх тэмцлийг жинхэнэ ёсоор явуулах хэрэгтэй боллоо.

Бид 1965 онд улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөгөөр өнгөрсөн онд байсан малаа 4,9 хувь буюу 64400 гаруй толгойгоор өсгөж жилийн эцэст бүх мал сүргээ 1 сая 369 мянга гаруй толгойд хүргэсэн байх үүрэг аваад байна. Энэ зорилтыг биелүүлэхийн тулд өнгөрсөн оны зүй бусаар хорогдсон малыг 3-ны 2 хувиар багасгаж чадвал 1965 оны улсын мал өсгөх төлөвлөгөөний цэвэр өсөлтийг 2 дахинаар давуулан биелүүлж чадах юм. Иймучраас бид малын зүй бусын хорогдлыг зогсоохын төлөө тэмцэх тэмцлийг үнэхээр хүчтэй болгох хэрэгтэй байна.

Мал сүргийг өсгөхийн үндсэн эх булгын нэг бол сүргийн доторхи хээлтэгч малын эзэлж байгаа хувийн жинг өсгөх явдал мөн.

Тус аймгийн 27 сум нэгдэл, сангийн аж ахуйнуудын дотроос 19 нь хээлтэгч малаа 27 мянга гаруй толгойгоор өсгөсөн байхад 8 сум—нэгдэл, сангийн аж ахуй хээлтэгч малаа 20 гаруй мянган толгойгоор хорогдуулсан боловч аймгийн хэмжээгээр хээлтэгч малаа 7000 гаруй толгойгоор өсгөж одоо мал сүргийн дотор хээлтэгч мал бүх малын 46 хувийг эзэлж байна. Малын зүй бусын хорогдлын голыг хээлтэгч мал ба нэг нас хүрээгүй төл мал эзэлж байгаа учраас хээлтэгч малын өсөлт хангалтгүй байна. Мал сүрэгт тарга хүчийг хичнээн сайн авахуулвал тэр нь байгалийн бэрхшээлийг эсэргүүцэх чадал, гарсан төлийн бялд чанар, элдэв өвчнийг эсэргүүцэн давах чадал зэрэг нь төдий чинээ сайн байдгийн дээр мал сүргийн мах нь хүнд бөгөөд тослог ихтэй, ноос үс нь арвин, сүү шим нь элбэг байдгийг шинжлэх ухааны нотолгоо манай тэргүүний малчдын туршлага батлан харуулж байна.

Малыг таргалуулна гэдгийг малын үржлийн буюу махны хүндийн жингийн талаас нь үзвэл нэг толгой малыг хоёр толгой болгоно гэсэн үг юм. Манай тэргүүний малчид малаа таргалуулах ажлыг цас хайлж, яргуй ба нялх ногоо гарч байгаа үеэс эхлэн намрын сөл тасарч өвс хагдартал нь үргэлжлүүлэн зохиодог байна. Баянцогтын сангийн аж ахуйн хоньчин Жигжид 1964 онд 700 эрлийз эр төлгийг дунджаар 35 кг-ийн хүндийн жинтэй хүлээн аваад 66 кг-ийн жинтэй болтол нь таргалуулж малын таргыг хоёр дахинаар нэмэгдүүлсэн ба хонь бүрээсээ 2500 грамм ноос авчээ. Жигжид малаа таргалуулахын тулд хавар,намар,зуны саруудад олон удаа нүүдэллэн нутаг шилж оторлодог байна.

Өнжүүл сумын "Ялалт" нэгдлийн хоньчин Ажваа 1960 оноос эхлэн хөдөлмөрийн баатар хоньчин Очирын туршлагаар ажиллан 1964 оны хавар тус бүр 25 кг хүндийн жинтэй 1000 төлөг, борлон хүлээж аваад намрын жигнэлтээр төлөг нэг бүрийг 51,6 кг, борлон бүрийг 39 кг-ийн жинтэй болтол таргалуулж малд тарга хүч авахуулах талаар хөдөлмөрийн баатрын амжилтаас давж гарсныг тэмдэглэхэд бахдалтай байна.

Алтанбулаг сумын „Монгол—Солонгосын найрамдал“ нэгдлийн үхэрчин Бүд 1964 оны 5 дугаар сард хүлээн авсан 160 охин шүдлэн үхрийг намар 11 дүгээр сард тус бүрийг цэврээр нь 109,8 кг тарга хүч нэмэгдүүлсэн байна. Манайд малыг отроор таргалуулах ажил ийнхүү нилээд хөгжиж байгаагаас 1964 снд аймгийн хэмжээгээр 694 мянга гаруй малыг буюу бүх мал сүргийн 53 хувийг 5 дугаар сарын нэгнээс 10 дугаар сарын 15-ныг хүртэл отроор таргалуулах ажлыг зохиосноор дунджаар эм хонь бараг 18 кг-аар, эм ямаа бүр 9 кг-аар тарга хүч нь нэмэгдсэн байна. Отроор мал таргалуулах энэ аргыг бид цаашид бүх малчдын үйл ажиллагаанд заншил болговол зохино.

Эдгээр тэргүүний малчдын туршлагаар хээлтэгч малд тарга хүч авахуулах ажлыг жинхэнэ ёсоор хийж чадвал бид хээлтэгч малын сувайралттай тэмцэж, хээлийг бүрэн авахуулах ба авсан хээлийг хэвлийд нь бойжуулж гарсан төлийг хорогдолгүй бойжуулж бүрэн чадна.

Манайд малыг хээлтүүлэхдээ үнээ ба бог мал дээр зохиомол хээлтүүлэг ба гардан нийлүүлгийг голлон хэрэглэдэг боллоо.

Энэ бол мал аж ахуйн үржлийн ажилд шинжлэх ухааныг нэвтрүүлж байгаа хэрэг мөн. Манайд нийлүүлгийг хийхдээ үнээг жилийн турш сааж саамы нь ашиглаж байхаар бодож тойрон эргэлтийн журмаар явуулах хэрэгтэй.

Бог малыг төллүүлэхдээ бүх мал нэгэн зэргээр төллөхөөр биш, түрүүчийн гарсан төл торниж дараачийн төлийг авч болохоор завсарлагатайгаар үечилсэн маягаар төллүүлэхээр зохион байгуулах нь чухал байна. Мал сүргийг өсгөх үндсэн эх булгийн нэг бол гарсан төл бүрийг бойжуулж мал болгох явдал мөн. Лүн сумын "Энх ту[…]" нэгдлийн хоньчин Жанчивын Рэнчиндорж нь сүүлийн гурван жил нийтдээ төллөх 1755 малаас 1919 төл бойжуулан авч эхээс нь 164 төлийг илүү бойжуулсны дотор зөвхөн 1964 оны зуд гачаалтай хүнд жилд бүх гарсан төлийнхөө 60 хувийг хөрвийн аргаар бойжуулж бүгд 779 хээлтэгч малаас 848 төл хүлээн авч эхээс нь 69 төл илүү бойжууллаа.

н. Рэнчиндоржийн энэ зүтгэл бүтээлийг нам засгаас өндрөөр үнэлж БНМАУ—ын 1964 оны төлийн аварга цолоор шагнав.

н.Рэнчиндорж нь төлийг бүрэн бойжуулахын үндэс нь эх малд дээд зэргийн тарга хүч авахуулах явдал мөн гэдгийг ойлгож хонио урьд зун, намарт нь билчээрийн соргог сайныг шилэн оторлуулах замаар тарга хүчийг жигд авахуулдаг ба уг хээлгэгч малаа бүрэн хээл авахуулж хээлтэй малыг ширүүн туух давчуу байранд шахцалдуулахыг цээрлэж,байнгын хариуллага арчиллагаа маллагаанд авч байдаг байна. Тэрчлэн тарга хүч муутай малыг төллөхөөс нь нэг сарын өмнө нэмэгдэл тэжээлд оруулж, төллөсөн хонио хөрвийн хугацаанд зохих тэжээлээр тэжээдэг байна.

Үүний тулд хаваржаандаа өвс тэжээл хүрэлцээтэй татах, хужир, шүү, хуурай хөх бууц нөөцлөх, хашаа саравч дулаалах, хайс тасал-

Үргэлжлэл нь 2 дугаар нүүрт)

# Тэргүүн туршлага, шинэ санаачлагыг бүтээлчээр нэвтрүүлье

## Аймгийн үйлдвэрлэлийн тэргүүний сайчуудын зөвлөлгөөн дээр аймгийн намын хорооны нарийн бичгийн дарга Д.Дамбажамцын тавьсан ИЛТГЭЛЭЭС

(*Үргэлжлэл*)

гааг тохижуулах, тэжээлийн онгоц, эмийн сан, ээлжийн уут, элгэвч, төлчний халад зэргийг урьдаас сайн бэлтгэдгээрээ ийм амжилтанд хүрсэн байна. Баянцагаан сумын „Өрнөх амьдрал“ нэгдлийн хоньчин эмэгтэй Гармаа ахлагчтай суурь 1964 онд суурийнхаа хүчээр саравчтай тохилог хашаа нэгийг барьж шаардагдах өвс хужир хуурай бууц, хайс элгэвч, ээлжийн уут зэрэг төлийн бэлтгэлийг бүрэн хангасны үндсэн дээр 484 төллөх бог малаас 511 төл хүлээн авч эхээс нь 27 төл илүү бойжуулсны дээр хонь бүрээсээ 1400 грамм уртын ноос, ямаа бүрээсээ 310 грамм ноолуур авч сууриараа хонь ямаанаасаа 4000 литр сүү сааж ашиглажээ.

н.Гармаа энэхүү амжилтаараа БНМАУ—ын 1964 оны төлийн аварга цолоор шагнагдав.

594 хониноос 619 хурга, 36 ямаанаас 50 ишиг хүлээн авч бойжуулсан Баянжаргалан сумын «Шинэ амьдрал» нэгдлийн хоньчин Жамбын Нямдаваа, 124 үнээнээс 124 тугал бойжуулсан Мөнгөнморьт сумын «Дэлгэржавхлант» нэгдлийн үхэрчин Гончигийн Ваанчиг, 61 ингэнээс 60 ботго бойжуулж, тэмээ бүрээсээ 5500 грамм ноос авсан Баян сумын «Монгол—Польшийн найрамдал» нэгдлийн тэмээчин Аюурын Галсандулам, 503 гүүнээс 474 унага бойжуулж улсын нормоос 199, төлөвлөгөөнөөс 131 унага илүү бойжуулсан Борнуурын сангийн аж ахуйн адуучин Дэндэвийн Чойжамц нарын зэрэг өдий төдий тэргүүний хүмүүсийн эгнээ өргөжиж байна. Тэргүүний хүмүүсийн туршлага байсаар байтал түүнийг нийтийн хүртээл болгож чадаагүй учраас тус аймгийн Тариат, Мөнгөнморьт, Лүн зэрэг 16 сум—нэгдэл, сум сангийн аж ахуйнууд 1964 оны төл бойжуулах төлөвлөгөөг 48 гаруй мянган толгойгоор тасалдуулсны уршгаар аймгийн хэмжээгээр 1964 оны төл бойжуулах төлөвлөгөө тасарсан юм. Хэрэв энэ гарзадсан төлөө бүрэн бойжуулсан бол манай аймаг 1963 онд байсан малаа 42 мянга гаруй толгойгоор өсгөж болох байлаа. Одоо бид 1965 оны төл хүлээн авч бойжуулах үед нэгэнт ороод байна. Энэ жил бид 600 гаруй мянган хээлтэгч малаас төл хүлээн авч бойжуулах ёстой. Иймд бид бүхний хамгийн гол хамгийн чухал зорилго бол төл нэг бүрийг мал болгох явдал мөн. Манайд төл малыг өвсөнд ормогц бойжиж гүйцлээ гэж үзээд арчиллагаа маллагаагий нь сулруулдгаас болж эдгээр төл маань дараах жилийн өвөл, хаварт онд орж чадахгүй элдэв шалтгаанаар гарздах явдал байна. Тийм учраас нялх төлийг нас биеий нь гүйцтэл арчилж хамгаалахад их анхаарах хэрэгтэй.

Мал аж ахуйг өсгөж, түүний ашиг шимийг нэмэгдүүлэхийн үндсийн үндэс бол мал аж ахуйг тэжээлийн бат баазтай болгох явдал юм. Малд хүрэлцэх хэмжээний тэжээлгүй байна гэдэг нь нэг өдрийн буюу нэг долоо хоногийн, сайндаа нэг сарын тасралтгүй үргэлжилсэн цасан шуурганд олонхи мал сүрэг маань сүйрч сүйднэ гэсэн үгээ. Үүний аюулыг ойлгож мал аж ахуйд тэжээлийн зохих хэмжээний баазтай болгохын тулд ихийг бүтээж байгаа тэргүүний хүмүүс олон байна.

Баянзүрх сумын Бямбаагийн Жамсран 1964 онд гар хадуураар 45 хоногийн дотор 100 шахам тонн өвс хадаж түүнийгээ өөрийн биеэр бухалдаж, нуруулдаж хашсан байна.

Мөн Баяндэлгэр сумын Загдын Лувсангомбо 1964 онд морин машинаар 246 га газрыг хадаж 123 тонн өвс авч бухалдан нуруулджээ.

Хэрэв эдгээр хүмүүсийн жишээгээр манай малчид ба манай сум сангийн аж ахуйнууд тэжээлийг бэлтгэж авдагсан бол бид малаа тэжээлийн бат баазтай болгож байгалийн бэрхшээлээс бүрэн хамгаалж ашиг шимийг нь дээшлүүлж чадна.

Гэтэл ийм хэмжээнд малчдыг хүргэж, арвин их өвс тэжээл бэлтгэж чадаагүйгээс өнгөрсөн өвөл хавар тус аймгийн бүх сумдын 3-ны нэг хувь буюу Алтанбулаг, Заамар,Угтаал зэрэг 9 сум зудын байдалд орсноос аймгийн хэмжээгээр 34 мянга гаруй толгой мал зудад үхэж 17000 толгой мал хээл хаяжээ.

1964 онд аймгийн хэмжээгээр бэлтгэх хадлангийн төлөвлөгөө 102,5 хувиар биелэгдэв.

Гэвч жил бүр байгалийн бэрхшээлд малаа үлэмж хэмжээгээр нэрвэгдүүлж байгаа Эрдэнэ,Дэлгэрхаан сумд 1964 оны хадлангийн төлөвлөгөөг бас л тасалдууллаа. Мөн Баянбараат, Алтанбулаг сумд авсан хадлан өвсөөрөө ядарсан малаа тэжээхийн оронд зэлүүд малд идүүлж ашиггүй сүйтгүүлэх явдал мөн л үзэгдсээр байна.

1965 онд тус аймаг 115,9 мянган тонн өвс бэлтгэнэ. Үүнийг 1965 оны 7 дугаар сарын 20-ноос эхлэн 9 дүгээр сарын 1-нд дуусгасан байх зорилтыг тавьж байна.

Энэ зорилтыг биелүүлэхийн тулд хадлангийн талбайг цэвэрлэх, цас тогтоох замаар газрын чийгийг хадгалах, хадлангийн багажийг 7 дугаар сарын 1-ний дотор бүрэн сэлбэн засуулж дуусгах, хадланд техникийн агрегатыг хэрэглэхийн хамтаар морьдыг машинд хөллөн сургах ажлуудыг одоогоос эхлэн зохиох хэрэгтэй байна. Тэргүүний хадланчин Жамсран,Лувсангомбо нарын туршлагаар өөрийнхөө хариуцсан нийгмийнхээ малд хэрэглэх тэжээлийн 60-аас доошгүй хувийг суурийнхаа хүчээр хадаж авдаг болох ёстой.

Мал аж ахуйг тэжээлээр хангахын хамтаар дулаан байраар хангах явдал мал аж ахуйг байгалийн бэрхшээлээс хамгаалж ашиг шимийг нь нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой. Манай аймаг бүх мал сүргээ түүний дотроос ялангуяа тугалах үнээ төллөх бог малын суурийг Баянцагаан сумын төлчин эмэгтэй Гармаа ахлагчтай суурийн жишээгээр хашаажуулж болох байна.

Гэвч энэ асуудал одоо болтол шийдвэрлэгдээгүй байна. Тус аймгийн Заамар, Лүн,Тариат, Алтанбулаг, Өндөрширээт, Өнжүүл, Эрдэнэсант, Баян, Баянцагаан, Баянбараат, Бүрэн зэрэг сумдын төллөх бог мал ба үнээн суурь одоо болтол 2 ээлжийн саравчтай хашаатай болоогүй ба одоогийн байгаа хашаа саравч нь чанараар муу түүнийгээ хайрлан хамгаалахгүй галын түлээнд хэрэглэх зэрэг зохисгүй байдал үргэлжилсээр байна.

Үүнийг эцэс болгож төллөх бог мал ба төлгөн суурь үнээний суурийг 1965 онд заавал *2* ээлжийн саравчтай хашаагаар хангах хэрэгтэй байна. Манайд мал сүргээ жилийн 4 улиралд усаар хангах ажлыг зохиосон тийм тэргүүний хүн одоо болтол товойн гарч ирэхгүй байна.

Гэтэл зэргэлдээ байгаа Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд нэг ээлжинд 500 тэмээг услах ундрагатай уурхайн худаг хэд хэдийг гаргасан малчид цөөнгүй байна. Үүнийг бид цаашдын ажилдаа хэрэглэвэл зохино.

Ялангуяа өвлийн улиралд худаг гаргавал жилийн ямарч улиралд усны ундаргаа өөрчлөгддөггүй учраас сүүлийн жилүүдэд Бүрэн, Өнжүүл, Баянцагаан зэрэг сумдад өвөл худаг гаргах хөдөлгөөн гарч ирсэн боловч тэр нь зохих дэмжлэгийг олсонгүй зогслоо. Үүнийг сэргээж малыг усаар хангахад их ажлыг хийх хэрэгтэй байна. Бидэнд мах ихтэй, ноос арвинтай, сүү ихтэй тийм мал хэрэгтэй юм.

Ийм учраас манай нам, засгаас мал аж ахуйг хөгжүүлэх хөгжлийн хэтийн чигийг бүсчлэн зааж тогтоосон билээ.

Тус аймгийн Батсүмбэр, Борнуур, Жаргалант,Баянцогт, Баянзүрх, Баяндэлгэр, Эрдэнэ зэрэг сумдын үхрийг сүүний чиглэлээр, Баянжаргалан, Баян,Өнжүүл, Дэлгэрхаан, Бүрэн зэрэг сумдын үхрийг мах сүүний чиглэлээр, Мөнгөнморьт, Эрдэнэ, Баяндэлгэр, Баянзүрх зэрэг сумдын хонийг нарийн ноосны чиглэлээр үржүүлэх ёстой юм.

Тус аймагт одоо цэвэр үүлдрийн хонь 3000 гаруйд хүрч 1963 оныхоос цэвэр үүлдрийн хонь 15,4 хувиар өссөн боловч цэвэр үүлдрийн хонь өсгөх төлөвлөгөөг 7,4 хувиар тасалдууллаа. Харин эрлийз хонь аймгийн хэмжээгээр 122 мянга гаруй толгойд хүрч өнгөрсөн оныхоосоо 7900 гаруй толгойгоор өсч хонь эрлийзжүүлэх улсын төлөвлөгөөг 106,6 хувиар биелүүллээ.

Мөнгөнморьт сумын «Дэлгэржавхлант» нэгдлийн хонин сүргийн 54 хувь нь эрлийзжиж хонь бүрээсээ дунджаар 2500 граммаас 3 кг ноос авч чаддаг болжээ.

Энэ нэгдлийн хонины ноосны орлого нь хонины аж ахуйгаас орсон орлогын 47,7 хувийг эзэлж байна. Гэтэл хонин сүргийн зөвхөн 10 хувийг эрлийзжүүлж байгаа Өндөрширээт сумын «Хөгжлийн зам» нэгдлийн хонины ноосны орлого нь хонины аж ахуйн орлогын дөнгөж 20 хувийг эзэлж байна. Энэ дүнгээс үзэхэд мал аж ахуйн үүлдэр угсааг сайжруулах нь хичнээн их өндөр ашгийг өгч байдаг нь тодорхой байна. Баян сумын хоньчин Чулууны Дорж 1964 онд 600 эрлийз хониноосоо дунджаар 2227 грамм ноос авч ашигласнаараа аймагтаа түрүүллээ.

Манай аймаг Улаанбаатар хотыг сүү цагаан идээгээр хангах гол үүргийг хүлээж байгаа учраас үхэр сүргийн гол нь сүүний чиглэлээр хөгжих ёстой юм. Манай аймгийн үхэр сүргийн дотор цэвэр үүлдрийн үнээ 1964 онд 4900 гаруй толгойд хүрч өндөр ашиг шимийн үхэр өнгөрсөн оныхоосоо 2000 гаруй толгойгоор өсч өндөр ашиг шимийн үнээ өсгөх төлөвлөгөө 161,2 хувиар биелэгдэв. Эрлийз үнээ 36 мянга гаруй толгойд хүрч өнгөрсөн оныхоос 1600-гаар өсч үнээг эрлийзжүүлэх төлөвлөгөө 119,6 хувиар биелэгдлээ. Манай тэргүүний саальчдаас үнээний саамыг нэмэгдүүлж байгаа гол арга бол тугалах үнээг тугалахаас нь өмнө дэлэнд иллэлт хийхийн хамтаар дарш,ус,төмс хивэг байцаа, манжин зэрэг нэмэгдэл, шүүслэг хүчит, тэжээлээр байнга тэжээж чухамхүү үнээг саах үедээ саалгаж байгаа үнээтэйгээ зөв харьцах энэ гурван гол аргыг хэрэглэснээрээ сүүний гарцыг 2 дахин нэмэгдүүлсэн байна.

Энэ аргыг хэрэглэсэн Батсүмбэрийн сангийн аж ахуйн саальчин Сэдэд 1964 онд цэвэр үүлдрийн үнээнээс дунджаар 4297 литр сүү саасан байна.

Гачууртын сангийн аж ахуйн саальчин Цэрэнпилийн Цэндээхүү 13 эрлийз үнээ бүрээс дунджаар 3336 литр сүү сааснаараа аймагтаа түрүүллээ. Мөн сангийн аж ахуйн залуу саальчин Б.Зийнаа нутгийн ба эрлийз холимог 18 нэмэх гунжин үнээ хариуцаж үнээ бүрээсээ 1629 литр сүү сааж сангийн аж ахуйгаас өгсөн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 1 дахинаар давуулан биелүүлжээ.

Зийнаа үнээгээ хайдагшуулж зуны улиралд өдөрт 3 удаа, өвөлд нь 2 удаа саадаг болсон ба зуны улиралд үнээгээ 2 удаа өвөлд нь нэг удаа тогтмол усалж үнээ бүрдээ өдөрт 4 кг хивэг саахын өмнө өгснөөр ивэлгээгий нь сайжруулж сүүний гарцыг нэмэгдүүлжээ.

Мөнгөнморьт сумын «Дэлгэржавхлант»нэгдлийн саальчин Должунай өөрийнхөө хариуцсан нутгийн үүлдрийн 15 үнээгээ ногооны сөл татрах үе 9 дүгээр сараас нэмэгдэл тэжээлд оруулснаараа нэг үнээнээс саах саамын хэмжээг дунджаар 1200 литрт хүргэж аймагтаа түрүүллээ.

Должунай ногооны шим татарч эхэлмэгц үнээ бүрдээ өдөр дутам хивэг овъёосны холимог 2-3 кг ногоон өвс 2 удаа тогтмол өгч хужир шүүг байранд нь байнга тавьж хэрэглэхийн зэрэгцээгээр өвөлд 1 удаа, зунд 2 удаа тогтмол усалдаг байна.

Тэрчлэн үнээгээ саахын өмнө дэлэнгий нь илж чийгтэй алчуураар арчих,саалтын дэс дарааг тогтоож нарийн журамтай саадгаас ийм амжилтанд хүрчээ.1964 онд Өнжүүл,Батсүмбэр,Угтаалцайдам,Гачуурт зэрэг 4 сум-нэгдэл,сум сангийн аж ахуйнууд улсад тушаах сүүний төлөвлөгөөг 163,1 хувь хүртэл биелүүлсэн байхад Баян,Алтанбулаг, Баяндэлгэр Баянзүрх,Заамар, Лүн, Тариат, Эрдэнэ Жаргалант зэрэг сумд улсад тушаах сүүний төлөвлөгөөг тасалдууллаа.

Энэ нь эдгээр сумдын удирдлагууд үнээний саамыг нэмэгдүүлсэн

(*Үргэлжлэл нь 3 дугаар нүүрт*)

# Тэргүүн туршлага, шинэ санаачлагыг бүтээлчээр нэвтрүүлье

## Аймгийн үйлдвэрлэлийн тэргүүний сайчуудын зөвлөлгөөн дээр аймгийн намын хорооны нарийн бичгийн дарга Д. Дамбажамцын тавьсан ИЛТГЭЛЭЭС

(*Төгсгөл*)

жил дараалан түрүүлж, олон түмэнд шуурхай соёлч боловсон үйлчилгээрээ нэрд гарсан төвийн худалдааны ангийн худалдагч Лувсанцэрэнгийн Долгор, 1964 онд 2027 тарвага агнаж 1000—аас дээш тарвага агнасан 8 анчдын манлайд нь гарч ирсэн Эрдэнэ сумын анчин Бадарчийн Дамба, 188 мянган төгрөгтэй тэнцүү амтлаг олон төрлийн хоолоор олон түмэндээ үйлчилсэн Баянчандманий тогооч Пансангийн Цэрэнхүү, 54 нэр төрлийн бэлтгэлийн зүйлээс 52-ыг нь 100 ба түүнээс дээш хувиар биелүүлж бэлтгэлд авсан түүхий эдийн зүйлээ өөрийнхөө санаачлан бэлтгэсэн байранд бүрэн давслах замаар бэлтгэлийн чанарыг сайжруулсан социалист хөдөлмөрийн гавшгайч, 28 жилийн турш худалдаанд агент хийж байгаа Батсүмбэрийн худалдааны агент Ажаахүүгийн Лхайдав, бэлтгэсэн бүх 44 тонн ноосоо 100 хувь гар шахуургаар манай худалдаа бэлтгэлийн ангиудын түүхэнд анх удаа преслэж тээврийн машины даацыг нэмэгдүүлэн, баглаа боодлын зардлыг хэмнэсэн одоо 14 дэх жилдээ түүхий эдийн эрхлэгч хийж байгаа Баяндэлгэрийн худалдаа бэлтгэлийн ангийн түүхий эдийн эрхлэгч Өсөхийн Мөнхбаяр нарын зэрэг тэргүүний хүмүүсийн үйл ажиллагаа манай худалдаа бэлтгэлийн ажлыг амжилтанд хүргэхэд ихээхэн нөлөөлж байна.

1965 он ба дараачийн жилийн худалдааны ажил дээр эдгээр хүмүүсийн туршлагыг дэлгэрүүлж нийтийн хүртээл болговол зохино.

Манай хөдөлмөрийн бүх хүмүүс ба ялангуяа өсвөрийн залуу үеийг социализм коммунизмын үзлээр, эх орноо хайрлан хамгаалж түүний хөгжлийг түргэтгэхийн төлөө ихийг бүтээх хөдөлмөрийн хүмүүжлээр пролетарийн интернационализмын үзлээр хүмүүжүүлэхэд, багш нарын үүрэг хариуцлага өндөр бөгөөд их юм.

Жаргалантын дунд сургуулийн орос хэлний багш Бунийн Сүрэн 21 жил орос хэлний багш хийхдээ орос хэлэнд олон зуун сурагчдыг сургажээ. Сүрэн сурагчдад гүн бат ойлгоц өгөхийн тулд орос хэлийг зөвхөн заадаг биш бас орос хэлний кабинет сургуульдаа байгуулж түүнд сурагчдаа бие даалган хичээллүүлэх аргыг чадамгай хэрэглэдэг байна. Ийм уйгагүй ажиллагааны үрээр 1964—1965 оны хичээлийн жилийн 2 дугаар улирлаар ангиа 100 хувийн дүнтэй сургажээ.

Тэрчлэн суурийн сурах бичгийг зохиож малчдын сурлага хүмүүжлийг дээшлүүлэхэд идэвхтэй оролцохын зэрэгцээгээр захирлын шалгалт гэгчийг санаачлан хийснээрээ сурагчдын сурлагыг 13 хувиар өсгөж багш нарын хичээлд энэ хичээлийн жилд 100 цагаар оролцож заах аргын зөвлөлгөөн өгөх зэргээр идэвхтэй ажиллаж байгаа Сэргэлэн сумын бага сургуулийн хичээлийн эрхлэгч Пунцагийн Очирбат 2 дугаар улирлын шалгалтаар даасан ангиа 100 хувь сургажээ.

Манай багш нар эдгээр тэргүүний багш нарын жишээн дээр сурч заах аргын шинжлэх ухааныг чадамгай эзэмшиж сурагчдын ерөнхий боловсролын гүн бат мэдлэгийг улам өсгөж сул сурлагатны тоог эрс багасгахын хамт сурагчдыг социалист коммунист үзлээр эх орноо хайрлан хамгаалж түүний хөгжлийг түргэтгэхийн төлөө ихийг бүтээх хөдөлмөрийн хүмүүжлээр пролетарийн интернационализмын үзлээр хүмүүжүүлэхэд хэрэгтэй бүхнийг хийх ёстой.

Аймгийн дүрслэх урлагийн эрхлэгч, аймгийн депутат, Дугаржавийн Шагдарсүрэн дүрслэх урлагийн 1964 оны төлөвлөгөөг 104 хувиар гүйцэтгүүлсний дээр өөрийнхөө уран бүтээлийн төлөвлөгөөг 103 хувиар биелүүлж „Атрын тухай" цуврал зураг хийсэн нь улсын уран бүтээлийн санд багтан оржээ.

Тэрээр санаачлан аймгийн соёлын ордны дэргэд ардын сайн дурын театр 1964 онд байгуулан энэ завсар «Жаргалыг хүссэн Мөнхөө», «Алтан загасны үлгэр», «Би эндээс явахгүй» гэдэг драмын жүжгийг биеэ дааж хэд хэдэн удаа тоглосон нь олон түмэнд өндрөөр үнэлэгдлээ.

Тэрчлэн урьд өмнө урлагийн талаар аймагтаа нилээд сүүлчийн байр эзэлж байсан Баянжаргалан суманд 20 хүнтэй үндэсний хөгжмийн багийг бий болгож хичээллүүлж байгаа Баянжаргалан сумын клубын найруулагч хөгжимчин Дагва, 568 удаа зургийн солилт хийж 22700 гаруй бүлэг, 6 сая гаруй метр кино зурагт үйлчилгээ хийж өөрийнхөө биеэр 3 хүний хийх ажил бүтээсэн аймгийн кино зургийн монтажчин Баянгийн Базар нарын зэрэг тэргүүний хүмүүсийг олноор нэрлэж болох байна.

Эдгээр хүмүүсийн жишээ туршлагыг 1965 оны ажил дээр нэвтрүүлж төлөвлөгөөт зорилгоо амжилттай биелүүлэхэд тус аймгийн соёл гэгээрлийн байгууллагуудын зорилт оршино.

Хүмүүсийн гол мөрөөдөл бол урт удаан наслаж, эрүүл энх амьдрахыг хүсдэгт оршдог.

Хүний энэ ариун хүслийг хангахад эмнэлгийн байгууллага, түүний эмч нар гол үүргийг биелүүлдэг билээ.

1964 онд амбулаториор 14500 гаруй хүн үзэж эмчлэн, 8400 гаруй ор хоног ашиглаж төлөвлөгөөг 5 хувиар давуулж, хариуцсан тасгийн хэв хүний үхлийг 27,8 хувиар бууруулсан аймгийн нэгдсэн больницын дотрын их эмч Борхүүгийн Алтангэрэл, сүүлийн 5 жилд хөдөлмөрчдийг эмээр хангах төлөвлөгөөг 327,6 хувь хүртэл биелүүлсэн Их Хайрханы уурхайн аптекийн эрхлэгч Рэнцэнгийн Мятав, сүүлийн 5 жилд жирэмсэн эмэгтэйчүүдийн 97 хувийг больницдоо хүлээн авч эрүүл энх төрүүлсний дээр, эх баригч хийсэн хугацаандаа 7583 хүүхдийг эрүүл энх эх барьж авснаараа олон түмэнд „Алтан гарт ээж" гэж нэрлэгдсэн эх баригч Лхамаа нарын туршлагыг ажилдаа нэвтрүүлж өмнөө тавигдсан зорилтоо амжилттай биелүүлэхэд аймгийн эмнэлгийн байгууллагын зорилт оршино.

НӨХӨД ӨӨ!

1965 онд бид нэг жилийнхээ ажлын дүнг гаргахын зэрэгцээгээр өнгөрсөн дөрвөн жилийг нэгтгэн бүхэл бүтэн 5 жилийн буюу 3 дугаар таван жилийн төлөвлөгөөг бүхэлд нь дүгнэх учраас 1965 он бол мал аж ахуйг өсгөх, төлөвлөгөө ба улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх бусад төлөвлөгөөнүүдийг үзүүлэлт бүрээр нь амжилттай биелүүлэхийг та биднээс шаардаж байна.

Бидний өмнө аж ахуй, соёлын олон төрлийн зорилт тавигдаж байна. Үүний дотроос хамгийн гол хамгийн чухал нь мал өсгөх төлөвлөгөөг биелүүлэх явдал мөн.

Энэ зорилтыг биелүүлэхэд бид юуны өмнө малын зүй бусын хорогдлыг дээд хэмжээгээр багасгах хэрэгтэй байна.

Өөрөөр хэлбэл бид малын зүй бусын хорогдлыг энэ 1965 онд өнгөрсөн оныхоосоо 80-аас доошгүй хувиар багасгах зорилт тавьж байна. Энэ нь өнгөрсөн оныхоосоо зуд өвчнөөр мал үхүүлэх, чоно нохойд идүүлэх, хээл хаяуулах, сувайруулах, гарсан төлийг, хорогдуулах зэрэг зүй бусын хорогдлыг 160 мянгаас доошгүй толгойгоор багасгана гэсэн үг юм.

Өнгөрсөн жилийн 6 дугаар сарын төгсгөлд 2—3 цаг үргэлжилсэн хүйтэн бороо тус аймгийн баруун хойт чиглэлийн 7, 8 сумыг хамарч ороход аймгийн хэмжээгээр 30 гаруй мянган толгой мал сүйдэв.

Үүнд; бид юу дутагдуулсан вэ гэвэл тэр үед малын ноосыг бүрэн авч дууссан байлаа.

Гэтэл манай орон нутгийн нам, улсын байгууллагууд ба малчид маань малынхаа ноосыг авсаны дараа малаа хүйтэн усанд хэд хэд дахин оруулж шумбуулах замаар цочроог нь гаргах ажлыг зохиосонгүйгээс болж бид 1964 оны зудаар хорогдсон бүх малын 4-ний 3 хувьтай тэнцэх ийм хохирлыг хүлээв.

Хэрэв малаа хүйтэн усанд шумбуулах замаар цочроогий нь гаргаж чадсан бол ийм хохирлыг хүлээхгүй байх ба хүлээвч тун бага хэмжээгээр хүлээх байсныг тэргүүний ажлын туршлага баталж байна.

Жишээ нь; Эрдэнэсант сумын 3 дугаар бригадын Цэвэгийн Сандаг, Цамбын Аюуш, 2 дугаар бригадын Дамдиндоржийн Балдан, Цэрэнпилийн Осорхүү нар 300—600 малаас нэгийг ч хорогдуулаагүй байхад зэргэлдээ байсан Тангадын Үржин, Дашийн Чагнаа, Бархасын Баатар нар тэргүүтэй олонхи малчид малаа өчнөөн төчнөөнөөр нь үхүүлсэн байна. Иймд 1965 оноос эхлэн бүх малаа бүрэн ноослож гүйцэхийг хүлээхгүйгээр түрүүчийн ноослосон малаасаа эхлэн бүх ноослосон малаа хэд хэд дахин хүйтэн усанд оруулж шумбуулах замаар цочроогий нь гаргах ажлыг зохиох хэрэгтэй байна.

Бид энэ онд малын зүй бусын хорогдлыг багасгаж чадвал мал өсгөх 1965 оны улсын төлөвлөгөөг 12,2 хувиар давуулан биелүүлж чадна.

Үүний зэрэгцээгээр бид аймгийн хэмжээгээр энэ жилийн хүлээн авч байгаа төлөө 98 хувиас доошгүйгээр бойжуулах зорилт тавьж байна. Энэ зорилтыг хангахын тулд гарсан төл нэг бүрийг мал болгохын төлөө тэмцэх тэмцлийг бүх ард түмний үйл хэрэг болгон дэвшүүлэн тавьж байна.

Бид мал аж ахуйгаа өсгөхийн зэрэгцээгээр түүнээс ашиглах ашиг шим тухайлбал нэг малаас авах ноос, сүүг дээд зэргээр ашиглах хэрэгтэй байна.

Манайд хөдөө аж ахуйн олон төрлийн машиныг хайр гамгүй эдэлж эвдэж сүйтгэх явдал үзэгдсээр байгаагийн дээр бэлэн байгаа техникийн хүч чадлыг дээд зэргээр ашиглаж газар тариалангийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилт мөн л хангалтгүй байна.

Бид тариаланг хөгжүүлэхэд тариалах газрын хэмжээг өсгөн нэмэгдүүлэхдээ гол нь биш харин тариалсан газрын нэг га-гаас авах ургацыг дээд зэргээр нэмэгдүүлэхэд гол анхаарлаа тавих ёстой.

Манай үйлдвэрлэл дээр ихийг бүтээж товойн гарч байгаа хүмүүсийн ажлын арга туршлага олон түмнийг хамарч тэдгээр олон түмэнд манай тэргүүний хүмүүсээс нөлөөлөх нөлөө хүрвэл зохих хэмжээндээ хүрээгүй байна.

Энэ нь манай тэргүүний хүмүүсийн туршлагыг орон нутгийн нам, улсын байгууллагуудаас дэмжин дэлгэрүүлэх нь сул манай тэргүүний хүмүүсүүд өөрсдөө олон түмэнд өөрийнхөө ажлын арга туршлагыг зааж хоцорч яваа хүмүүсээ дагуулан сургах нь хангалтгүй байгаад оршиж байгаа юмаа.

Манай тэргүүний бригадууд 2—3 бригад тасгийг, манай тэргүүний сумд 1—2 сумыг өөрийн жишээн дээр сургаж харилцан бие биесдээ туслаж дэмжих социалист нөхөрлөлийн ёсоор ажиллаж чадвал манай өмнө тавигдсан зорилго хэзээд амжилттай биелэгдэнэ гэдэгт итгэж болно.

Бидэнд нөхөрсөг хамтын ажиллагаа дутагдаж байгаа нь манай ажилд багагүй саад болж байна гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй байна. Алдарт намынхаа VI бүгд хурал ба ардын их хурлын 5 дахь удаагийн 8 дугаар чуулган болон аймгийн намын 6 дугаар бүгд хурал ба аймгийн АДХ—ын 6 дахь удаагийн 7 дугаар чуулганы шийдвэрийг амьдралдаа хэрэгжүүлж айл өрхөөсөө эхлээд суурь, хэсэг, бригад, тасаг, сум—нэгдэл, сум сангийн аж ахуй, мал аж ахуйн машинт станц, үйлдвэр барилга, худалдаа, тээвэр, эмнэлэг, гэгээрэл, сургууль, ахуй хангамж, үйлчилгээний бүх газрууд улс ардын аж ахуйн төлөвлөгөөг жигд амжилттай биелүүлсний хувьд ч тохижилт, соёлжилтын талаар ч улсын тэргүүний аймгийн хэмжээнд хүрч эх орондоо социализм байгуулах их үйл хэрэгт улам ихийг бүтээхийг энэ зөвлөлгөөнд оролцож байгаа та бүхэн болон та бүхнээр дамжуулан тус аймгийн бүх бүтээлч хөдөлмөрчдийг аймгийн намын хороо, АДХ—ын Гүйцэтгэх захиргаа уриалан дуудаж байна.

Хариуцлагатай эрхлэгч Н. МӨНХӨӨ

(Х—00408) «Анхдугаар таван жил» сонины газар хэвлэв.